

# “МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон “Монос хүнс” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн, хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. “Монос хүнс” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг энэхүү тогтоолын хавсралт №01-ээр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Х.АНАНД

**Монос Хүнс ХК-ийн 2023 оны санхүү, үйл ажиллагааны тайланд өгөх  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт**

Монос Хүнс ХК-ийн санхүү болон үйл ажиллагааны дүгнэлт, 2023 оны зорилтын биелэлтийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Монос Хүнс ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2023 онд компанийг удирдлагаар хангахдаа сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгон, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, үүрэг зөвлөмж, төлөвлөгөөт зорилтуудыг хэрэгжүүлэн, тайлант хугацаанд тогтмол хуралдаж компанийн үйл ажиллагаанд нийт 38 үүрэг зөвлөмж өгснөөс 94%-ийн биелэлттэй байна.

Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, оролцогч талуудаас засаглалын хувьд чухалчлан авч үздэг тогтвортой хөгжлийн зорилтын хэрэгжилт, байгаль орчин, нийгэм, засаглалыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хэвшүүлэх “MFC Green foot print” төслийг 2022 оноос санаачлан хэрэгжүүлж, хараат бус хөндлөнгийн байгууллагаар байгаль орчин нийгмийн засаглалын үнэлгээг гүйцэтгүүлж үйл ажиллагаандаа тайлагнаж эхэлсэн нь томоохон амжилт байлаа.

Монгол эрчүүдийн дундаж насжилт, эрүүл мэндийн асуудлыг хөндсөн “Хэнэгтэй Монгол эр хүн” төсөл, “Үрсээ устай үлдээ” аян, жил бүр эмнэлгийн хүүхдийн өрөө тохижуулах санаачлага, хэрэглэгчдэд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг хамт олны санаачлагаар хэрэгжүүлж буй нийгмийн нөлөөлөл, манлайлын ажлуудад ТУЗ-ийн зүгээс талархалтай байгааг дурдах нь зүйтэй юм.

2023 оны голлох төсөл болох MFC 2.0-ийн төслийн хүрээнд эрүүл мэндийн шингэн хүнс болон хуурай хүнсний үйлдвэрлэл, чанарын хяналт баталгаажуулалт, инженер техникийн үйл ажиллагааг нэгдсэн байршилд төвлөрүүлж, шингэн хүнсний үйлдвэрийн хүчин чадлыг 2.5 дахин нэмэгдүүлэх, автоматжуулсан технологи, ногоон шалгуурыг хангахуйц тоног төхөөрөмжийн сонголт бүхий, 6000 кв талбайтай эрүүл мэндийн нэгдсэн үйлдвэрээ ашиглалтад оруулж эхлээд байна.

Түүнчлэн өнгөрсөн 10 жилийн үйл ажиллагааны өсөлт хөгжил, гадаад дотоод орчны өөрчлөлт чиг хандлага, ирээдүйн бизнесийн цар хүрээ, стратеги чиглэлд нийцүүлэн компанийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг шинэчлэн баталсныг та бүхэнд танилцууллаа.

Монос Хүнс ХК-ийн хамт олон нь 2023 онд 31.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 3.5 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж төлөвлөсөн зорилгоо 95%-аар биелүүлж, өмнөх оноос борлуулалтын орлогоо 12%-аар, цэвэр ашгаа 9%-иар өсгөж ажилласан, үндсэн үйл ажиллагааг тогтвортой үр дүнтэй удирдахын зэрэгцээ компанийн ойрын ирээдүйд өсөлт гаргах чухал төсөл MFC 2.0 төслийг 93%-ийн биелэлттэй хэрэгжүүлсэн, Киргиз, Австрали улсад бүтээгдэхүүнээ бүртгүүлж экспортын тэлэлтийг хийх суурь бэлтгэлийг хангаж үр дүн ажилласан зэргийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс “САЙН” ажилласан хэмээн дүгнэж байна.

Компани нь цаашдын үйл ажиллагаандаа дараах чиглэлийг анхаарахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс зөвлөж байна. Үүнд:

- MFC 2.0 төслийн хаалтыг хийж үйлдвэрийг бүрэн ашиглаж эхлэх, үйлдвэрийн хүчин чадлаас хамаарсан тасалдлыг бууруулах
- ТУЗ-аар хэлэлцүүлж баталсан 2024 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах
- Үйл ажиллагаандаа хэвшүүлсэн сайн засаглалын зарчим, нийгмийн нөлөөллийн ажлуудаа тасралтгүй сайжруулах

**Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл**

# “МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр  
сарын 20-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар  
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2024 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос гаргасан саналыг 2024 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн цалин, урамшууллын хэмжээг болон хурлын үйл ажиллагаанд шаардагдах 2024 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №01-д заасны дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолоор батлагдсан төсөвт хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшуулал хорооны дарга/Б.Гантулга/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Х.АНАНД



2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн  
ХЭЭХ-ын 12 тоот тогтоолын хавсралт №01

## МОНОС ХҮНС ХК ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

	/мянган төгрөг/
<b>1. ТУЗ-ийн хурлын зардал</b>	<b>12,000</b>
• ТУЗ-ийн ээлжит хурал	8,000
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	4,000
<b>2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ</b>	<b>78,489</b>
• ТУЗ-ийн ээлжит хурал	59,289
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	19,200
<b>3. Сургалтын зардал</b>	<b>2,000</b>
<b>3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал</b>	<b>40,000</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>132,489</b>

**“МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2024 оны 04 дүгээр  
сарын 20 -ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

“Монос хүнс” ХК-ийн дүрэмд  
нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалт, 2024 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэр, хурлын Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монос хүнс” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлтийг оруулж, нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг энэ тогтоолын хавсралт №01-ээр баталсугай.
2. Компанийн дүрэмд дээрх нэмэлт өөрчлөлт оруулсан заалтаас бусад зүйл заалтад өөрчлөлт оруулаагүй хэвээр мөрдөгдөнө.
3. Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /А.Отгондарь/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Х.АНАНД

1.1. Компанийн албан ёсны хаяг:

Монос хүнс ХК  
Сонсголонгийн зам гудамж 32/3 тоот  
Үйлдвэрийн баруун бүс,  
Баянгол дүүрэг, 20 дугаар хороо  
Улаанбаатар -16103, Монгол улс  
Харилцах утас: (+976) 7777-3525  
Цахим шуудан: foods@monos.mn  
Цахим хаяг: www.monosfoods.mn

- 7.2. Компанийн ТУЗ нь 11 (арван нэг) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 5 (тав) нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 3 (гурав) жилийн хугацаатай сонгох ба ТУЗ-ийн гишүүний эрх дараагийн ТУЗ-ийн гишүүд сонгогдсоноор дуусгавар болно. ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгож болох бөгөөд хувьцаа эзэмшигч биш этгээд ТУЗ-ийн гишүүнээр сонгож ажиллуулж болно.
- 7.15. ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болох бөгөөд өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготойгоор 1. Аудит, эрсдэлийн хороо 2. Нэр дэвшүүлэх хороо 3. Стратеги, бизнес хөгжлийн хороо 4. Цалин урамшууллын хороо тус тус байгуулан ажиллуулна.
- 7.16. Аудит, эрсдэлийн хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна. Үүнд:
- 7.16.6. Компанийн зорилго, алсын хараатай уялдуулан хүлээж болох эрсдэлийн төрөл, хэмжээ хязгаарыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлэх,
  - 7.16.7. Компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг тогтмол хянаж, эрсдэлийг хянах, илрүүлэх дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг ТУЗ-д танилцуулах,
  - 7.16.8. Компанид тулгарч байгаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдаж байгаа талаар бүрэн гүйцэд мэдээллийг гүйцэтгэх удирдлагаас аван зөвлөн чиглүүлэх,
  - 7.16.9. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, журам, хэрэгжилтийн талаар мэдээллийг компанийн тайлан, цахим хуудаст мэдээлж байх
- 7.17. Нэр дэвшүүлэх хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.17.8. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг
- 7.19. Цалин урамшууллын хороо нь дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 7.19.1. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
  - 7.19.2. ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;
  - 7.19.3. Компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;
  - 7.19.4. Компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг

- 8.11. Гүйцэтгэх захирлын эдлэх эрх хэмжээг түүнтэй байгуулсан гэрээнд тодорхой тусгах бөгөөд Гүйцэтгэх захирал нь дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:
- 8.11.9. ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн даргаас бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд хяналт тавих, үнэлгээ өгөх, өгсөн үнэлгээгээ ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороонд танилцуулан дүгнэлт гаргуулах;
- 9.1 ТУЗ-ийн гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал, зэрэг компанийн албан ёсны шийдвэр гаргахад оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.
- 10.7. Дараах этгээдийг компанийн дотоод аудитор болон аудитын байгууллагаар сонгон ажиллуулахыг хориглоно. Үүнд:
- 10.7.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрт нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;
- 10.7.2. компани болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эзэмшдэг бол;
- 10.7.3. компанигай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол;
- 10.8. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1-д заасан компанийн бичиг баримтыг Компани нь хяналт шалгалт, лавлагаа, түүх, архивын зорилгоор холбогдох хуульд зааснаар хадгална.
- 11.4. Санхүүгийн тайлан нь Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.1-дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан байх ба баталгаажуулсан тайланг улирал, жилээр гарган Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлнэ.

**/Дүрмийн 12 дугаар бүлгийг хасч, заалтыг 10 дугаар бүлэгт нэгтгэсэн/**

**/Дүрмийн 13, 14 дүгээр бүлгийн дугаарлалт засагдсан/**